

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН VI АНГИЙН  
МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар А

ХУГАЦАА: 60 МИНУТ

1-р хэсэг Сонгох тест ( Бодлого бүр 1 оноо)

НИЙТ ОНОО: 30

1. 45 ба 75 тоонуудын ХИЕХ-ийг олоорой. /1 оноо /

- A. 5                                      B. 1                                      C. 15                                      D. 225

2.  $-5a + 11a - 9a + a = ?$  /1 оноо /

- A.  $-2a$                                       B.  $-26a$                                       C.  $-3a$                                       D.  $-25a$

3.  $\frac{1}{2}$  ба  $\frac{3}{4}$ -ын хооронд орших тоо аль нь вэ? /1 оноо /


- A. 0,2                                      B. 0,4                                      C. 0,6                                      D. 0,8

4.  $2x - 5 = 1$  шугаман тэгшитгэлийг бод. / 1 оноо /

- A. 2                                      B. 3                                      C. -2                                      D. -3

5. Дараах зургаас x-ийн утгыг олоорой. /1 оноо/

- A.  $180^\circ$                                       B.  $126^\circ$                                       C.  $54^\circ$                                       D. 10



6. Дэлгүүрт 5 төрлийн аяга, 3 төрлийн таваг, 4 төрлийн халбага зарж байсан. Аяга, халбага, таваг гэсэн иж бүрдлийг хэдэн янзаар худалдан авах вэ? / 1 оноо /

- A. 80                                      B. 60                                      C. 90                                      D. 100

7. 10 шүдний эмч тутмын 6 нь чихэргүй шүдний оо хэрэглэхийг зөвлөдөг бол нийт эмч нарын хэдэн хувь нь чихэргүй оо хэрэглэхийг зөвлөдөггүй вэ? / 1 оноо /


- A. 20%                                      B. 30%                                      C. 40%                                      D. 60%

8. 81, 80, 78, 75,.... дарааллын 7-р гишүүн нь хэд вэ? / 1 оноо/

- A. 71                                      B. 66                                      C. 60                                      D. 53

9. Зурагт өгсөн шулууны тэгшитгэлийг ол. / 1 оноо /




- A.  $y = 1$                                       B.  $y = 0,5x$                                       C.  $y = x$                                       D.  $y = -x$



10. Илэрхийллийг хялбарчил.  $3(x - 2) - 4 = ?$  / 1 оноо

- A.  $3x + 10$                                       B.  $3x - 10$                                       C.  $2x - 10$                                       D.  $3x + 2$

11. Дараах дүрсүүдийг ажиглаад параллелиар зөөсөн хувиргалтыг сонгоорой. / 1 оноо /



12. 1-10 хүртлэх цифрээс нэгийг сонгоход тэгш цифр гарч ирэх магадлалыг ол. / 1 оноо /

- A. 0.1                                      B. 0.2                                      C. 0.5                                      D. 0.8

13.  $5 \cdot \sqrt{36} - 7^2 = ?$  / 1 оноо /

- A. -6                                      B. 39                                      C. -19                                      D. -2

14. Өгөөж чихэр боовны үйлдвэрт 2т боов үйлдвэрлэсэн. Түүний 1/5-ыг худалдаанд гаргасан.

Үлдсэн боовны 1/4 -ийг цагаан сараар ахмадуудад бэлэглэсэн бол хэчнээн хэмжээний боов үлдсэн бэ? / 1 оноо/

- A. 1200 кг                                      B. 1500 кг                                      C. 100 кг                                      D. 2000 кг

15. Хаалтнаас ерөнхий үржигдэхүүн гаргаарай.  $36a - 9b =$  / 1 оноо /


- A.  $9(4a - b)$       B.  $9a(4a + b)$       C.  $9(4a - 9b)$       D.  $9(4a - 1)$

16. Хэрэв  $a = 5, b = 6$  бол  $\frac{a-1}{b+2}$ -ийн утгыг ол. / 1 оноо /

- A.  $\frac{1}{3}$       B. 1      C. 3      D.  $\frac{1}{2}$

17. Нэг жижиг параллелолипедийн ирмэгүүд 2 см, 3 см, 5 см бол дараах биетүүдийн эзэлхүүнийг олоорой. / 1 оноо /

- A. 720 см.куб      B. 240 см.куб      C. 120 см.куб      D. 128 см.куб



18. 3, 3, 3, 5, 5, 7, 8, 8, 8, 8 өгөгдлийн медиан ба далайцыг ол. / 1 оноо /

- A. медиан 6, далайц 5      B. медиан 5, далайц 6      C. медиан 7, далайц 5      D. медиан 6, далайц 4

## 2-р хэсэг


## Задгай даалгавар

2.1 Огтлолцсон хоёр шулууны хооронд орших өнцгүүдийн нэг нь  $55^\circ$  бол /2 оноо/

- A. Өнцгүүдийг зураг дээр тэмдэглээрэй.      B. Өнцгүүдийг олоорой.

2.2 Баганан диаграмм ашиглан асуултанд хариулаарай. /2 оноо/


- A. 2 ном уншсан хэдэн сурагч байсан бэ?  
B. 3 буюу түүнээс дээш ном уншсан хэдэн сурагч байсан бэ?



2.3 5-д хуваахад 3 үлдэгдэл өгдөг тоонуудаар дараалал зохиожээ. /2 оноо/

- A. Дарааллын эхний 3 гишүүнийг бичээрэй.      B. Энэ дарааллын 10 дугаар гишүүнийг олоорой.

2.4 Өгсөн тооны процентуудыг тус тус олоорой. /2 оноо/



2.5 Координатын хавтгай дээр  $A(1; -6), B(3; -1), C(0; -1)$  цэгүүдийг тэмдэглэж: /2 оноо/

- A. ABC гурвалжин байгуулаарай.      B. Ох тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй хувиргаарай.

2.6 Х, Y, C, Л, Э, Н гэсэн үсгүүдийг нэг нэгээр нь бичсэн картууд байв. Таамгаар нэг карт сонгоход /2 оноо/

- A. Эгшиг үсэг таарах      B. Гийгүүлэгч үсэг таарах магадлалыг тус тус ол.

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН VI АНГИЙН  
МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар В

ХУГАЦАА: 60 МИНУТ

**1-р хэсэг Сонгох тест ( Бодлого бүр 1 оноо)**

НИЙТ ОНОО: 30

1. 30 ба 18 тоонуудын ХБЕХ-ийг олоорой. / 1 оноо /

- A. 90                      B. 120                      C. 150                      D. 180

2.  $3x - 4x + 5x = ?$  / 1 оноо /

- A.  $-x$                       B.  $4x$                       C.  $12x$                       D.  $6x$

3.  $\frac{1}{2}$  ба  $\frac{4}{5}$ -ын хооронд орших тоо аль нь вэ? / 1 оноо /


- A. 0,2                      B. 0,4                      C. 0,5                      D. 0,6

4.  $3x - 6 = 42$  шугаман тэгшитгэлийг бод. / 1 оноо /

- A. 12                      B. 48                      C. 36                      D. 16

5. Дараах зургаас  $x$ -ийн утгыг олоорой. / 1 оноо /

- A.  $50^\circ$                       B.  $75^\circ$                       C.  $130^\circ$                       D.  $100^\circ$



6. Дэлгүүрт 6 төрлийн өмд, 3 төрлийн цамц, 7 төрлийн гутал зарж байсан. Өмд, цамц, гуталны хослолыг хэдэн янзаар худалдан авах вэ? / 1 оноо /

- A. 106                      B. 116                      C. 126                      D. 136

7. 10 шүдний эмч тутмын 6 нь чихэргүй шүдний оо хэрэглэхийг зөвлөдөг бол нийт эмч нарын хэдэн хувь нь чихэргүй оо хэрэглэхийг зөвлөдөг вэ? / 1 оноо

- A. 20%                      B. 30%                      C. 40%                      D. 60%

8. 25, 50, 100, ... дарааллын 6-р гишүүн нь хэд вэ? / 1 оноо /

- A. 250                      B. 400                      C. 600                      D. 800


9. Зурагт өгсөн шулууны тэгшитгэлийг ол. / 1 оноо /

- A.  $y = 2$                       B.  $y = 2x$                       C.  $y = -x$                       D.  $y = x$

10. Илэрхийллийг хялбарчил.  $2(3y + 1) - 4(y - 2) = ?$  / 1 оноо /

- A.  $2y + 10$                       B.  $4y - 10$                       C.  $7y - 6$                       D.  $8y + 5$

11. Дараах дүрсүүдийг ажиглаад эргүүлэлт хийсэн хувиргалтыг сонгоорой. / 1 оноо /



12. 1-10 хүртлэх цифрээс нэгийг сонгоход сондгой цифр гарч ирэх магадлалыг ол. / 1 оноо /

- A. 0.1                      B. 0.2                      C. 0.5                      D. 0.8

13.  $-3 \cdot \sqrt{81} + 8^2 = ?$  / 1 оноо /

- A. 37                      B. 64                      C. -91                      D. 81

14. Өгөөж чихэр боовны үйлдвэр 2т чихэр үйлдвэрлэсэн. Түүний  $\frac{1}{4}$ -ийг хүүхдийн баярын бэлгэнд зориулав. Үлдсэн чихрийн  $\frac{1}{3}$ -ыг худалдаанд гаргасан бол хичнээн хэмжээний чихэр худалдаанд гаргасан бэ? / 1 оноо /

- A. 250 кг                      B. 7500 кг                      C. 1000 кг                      D. 500 кг

15. Хаалтнаас ерөнхий үржигдэхүүн гаргаарай.  $16x + 24y = / 1$  оноо /

A.  $8(2x + 3y)$

B.  $8y(2x + 3)$

C.  $6(2x + 4y)$

D.  $2x(6 + 12y)$

16. Хэрэв  $a = 6, b = 3$  бол  $\frac{a-1}{b+2}$ -ийн утгыг ол. / 1 оноо /

A.  $\frac{1}{4}$

B. 1

C. 2

D.  $\frac{1}{2}$


17. Нэг жижиг параллелолипедийн ирмэгүүд 2 см, 4 см, 5 см бол дараах биетүүдийн эзэлхүүнийг олоорой. / 1 оноо /

A. 40см.куб

B. 400 см.куб

C. 200 см.куб

D. 560 см.куб



18. 4, 5, 4, 3, 5, 3, 2, 4, 7, 5 өгөгдлийн медиан ба далайцыг ол. / 1 оноо /

A. медиан 4, далайц 5

B. медиан 4, далайц 1

C. медиан 3, далайц 2

D. медиан 2, далайц 5

**2-р хэсэг Задгай даалгавар**

2.1 Огтлолцсон хоёр шулууны хооронд орших өнцгүүдийн нэг нь  $45^\circ$  бол /2 оноо/

A. Өнцгүүдийг зураг дээр тэмдэглээрэй.

B. Өнцгүүдийг олоорой.

2.2 Пиктограммыг ашиглан асуултанд хариулаарай. /2 оноо/

а. Маралд хэдэн алим байсан бэ?

б. Бат, Туяа хоёр нийлээд хэдэн алимтай байсан бэ?


Марал		<p>Түлхүүр:</p> = 2 алим
Бат		
Билгүүн		
Туяа		

2.3 3-т хуваахад 1 үлдэгдэл өгдөг тоонуудаар дараалал зохиожээ. /2оноо/

A. Дарааллын эхний 4 гишүүнийг бичээрэй

B. Энэ дарааллын 10 дугаар гишүүнийг олоорой.


2.4 Өгсөн тооны процентуудыг тус тус олоорой. / 2 оноо /



2.5 Координатын хавтгай дээр  $A(-5; 1), B(-1; 4), C(0; 1)$  цэгүүдийг тэмдэглэж: /2 оноо/

A. ABC гурвалжин байгуулаарай

B. Оу тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй хувиргаарай.



2.6 М, А,Г, А, Д, Л, А, Л гэсэн үсгүүдийг нэг нэгээр нь бичсэн картууд байв. Таамгаар нэг карт сонгоход: /2 оноо/

А.Гийгүүлэгч үсэг таарах

В. Л үсэг таарах магадлалыг тус тус ол.

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН VI АНГИЙН  
МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар С

ХУГАЦАА: 60 МИНУТ  
НИЙТ ОНОО: 30

**1-р хэсэг Сонгох тест ( Бодлого бүр 1 оноо )**

1. 555 ба 275 тоонуудын ХИЕХ-ийг олоорой. / 1 оноо /

- A. 3                                  B. 7                                  C. 5                                  D. 15

2.  $-3x + 4x - 6x = ?$  / 1 оноо /

- A.  $5x$                                   B.  $-7$                                   C.  $-5x$                                   D.  $-x$

3.  $\frac{3}{5}$  ба  $\frac{4}{5}$ -ын хооронд орших тоо аль нь вэ? / 1 оноо /


- A. 0,2                                  B. 0,7                                  C. 0,6                                  D. 0,8

4.  $3x - 5 = 4$  шугаман тэгшитгэлийг бод. / 1 оноо /

- A. 2                                  B. 3                                  C.  $-2$                                   D.  $-3$

5. Дараах зургаас  $x$ -ийн утгыг олоорой. /1оноо/

- A.  $30^\circ$                                   B.  $40^\circ$                                   C.  $110^\circ$                                   D.  $140^\circ$



6. Улаанбаатараас Дархан хүрэх 3 ялгаатай зам байдаг. Дарханаас Эрдэнэт хүртэл 4 ялгаатай зам байдаг. Тэгвэл Улаанбаатараас Эрдэнэт хүртэл хэдэн ялгаатай зам байгаа вэ? / 1 оноо /

- A. 10                                  B. 11                                  C. 12                                  D. 13

7. 5 шүдний эмч тутмын 3 нь чихэргүй шүдний оо хэрэглэхийг зөвлөдөг бол нийт эмч нарын хэдэн хувь нь чихэргүй оо хэрэглэхийг зөвлөдөггүй вэ? / 1 оноо /

- A. 20%                                  B. 30%                                  C. 40%                                  D. 60%

8. 91, 90, 88, 85,..... дарааллын 7-р гишүүн нь хэд вэ? / 1 оноо /


- A. 81                                  B. 76                                  C. 70                                  D. 63

9. Зурагт өгсөн шулууны тэгшитгэлийг ол. / 1 оноо /

- A.  $y = 1$                                   B.  $y = 0,5x$                                   C.  $y = x$                                   D.  $y = -x$

10. Илэрхийллийг хялбарчил.  $-2(n - 3) + 4(n - 5) = ?$  / 1 оноо /

- A.  $2n - 14$                                   B.  $2n - 26$                                   C.  $6n + 26$                                   D.  $-6n - 14$



11. Дараах дүрсүүдийг ажиглаад эргүүлэлт хийсэн хувиргалтыг сонгоорой. / 1 оноо

- A.                                   B.                                   C.                                   D. 

12. 0-9 хүртлэх 10 цифрээс нэгийг сонгоход тэгш цифр гарч ирэх магадлалыг ол. / 1 оноо /

- A. 0.1                                  B. 0.2                                  C. 0.5                                  D. 0.8

13.  $3 \cdot \sqrt{25} - 8^2 = ?$  / 1 оноо /

A. -6

B. 59

C. -49

D. -1

14. Нийт ногооны  $\frac{1}{2}$ -д нь хүнсний ногоо, хүнсний ногооны  $\frac{3}{5}$ -д төмс тарьсан бол нийт талбайн ямар хэсэгт төмс тарьсан бэ? / 1 оноо /

A.  $\frac{1}{10}$

B.  $\frac{3}{10}$

C.  $\frac{7}{10}$

D.  $\frac{9}{10}$

15. Хаалтнаас ерөнхий үржигдэхүүн гаргаарай  $24a - 16b =$  / 1 оноо /

A.  $2(12a + 8b)$

B.  $4a(6 + 4b)$

C.  $8(3a - 2b)$

D.  $8b(3a - 2)$

16. Хэрэв  $a = 3, b = 4$  бол  $\frac{a-1}{b+2}$ -ийн утгыг ол. / 1 оноо /

A.  $\frac{1}{3}$

B. 1

C. 3

D.  $\frac{1}{2}$


17. Нэг жижиг параллелопипедийн ирмэгүүд 3 см, 5 см, 8 см бол дараах биетүүдийн эзэлхүүнийг олоорой. / 1 оноо /

A. 720 см.куб

B. 960 см.куб

C. 120 см.куб

D. 128 см.куб



18. 3; 2.25; 3.3; 6.25; 3; 3.2 өгөгдлийн медиан ба далайцыг ол. / 1 оноо /

A. медиан 3.1, далайц 4

B. медиан 4,63, далайц 3.25

C. медиан 3, далайц 4

D. медиан 2.5, далайц 4.25

### 2-р хэсэг Задгай даалгавар

2.1 Огтлолцсон хоёр шулуунаар үүсэх өнцгүүдийн хоёр өнцгийн нийлбэр нь  $120^\circ$  бол /2 оноо/

A. Өнцгүүдээ зураарай

B. Өнцгүүдийг олоорой.

2.2 Багана диаграмм ашиглан асуултанд хариулаарай. /2оноо/

A. Нэг ч ном уншаагүй хэдэн сурагч байсан бэ?

B. 4 буюу түүнээс дээш ном уншсан хэдэн сурагч байсан бэ?



2.3 5-д хуваахад 2 үлдэгдэл өгдөг тоонуудаар дараалал зохиожээ. /2оноо/

A. Дарааллын эхний 4 гишүүнийг бичээрэй

B. Энэ дарааллын 15 дугаар гишүүнийг

олоорой.

2.4 Нэг нь нөгөөгөөсөө 2 дахин их хурдтай хоёр машин хоорондоо 180 км зайтай хоёр хотоос нэгэн зэрэг угталцан гарч 3 цаг яваад зөржээ. /2 оноо/

A. Машин тус бүрийн хурдыг олоорой.


B. Хэдэн цагийн дараа тэдний хоорондох зай 60 км

болох вэ

2.5 Координатын хавтгай дээр  $A(1; -6), B(3; -1), C(0; -1)$  цэгүүдийг тэмдэглэж: /2оноо/

A. ABC гурвалжин байгуулаарай.

В.Оу тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй хувиргаарай.



2.6 Б, О, Л, О, М, Ж гэсэн үсгүүдийг нэг нэгээр нь бичсэн картууд байв. Таамгаар нэг карт сонгоход:

A. Эгшиг үсэг таарах

В. Л үсэг таарах магадлалыг тус тус ол.



“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН VI АНГИЙН  
МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар D

ХУГАЦАА: 60 МИНУТ  
НИЙТ ОНОО: 30

**1-р хэсэг Сонгох тест ( Бодлого бүр 1 оноо )**

1. 22 ба 77 тоонуудын ХБЕХ-ийг олоорой. / 1 оноо /

- A. 2                                      B. 7                                      C. 11                                      D. 154

2.  $-8x - 5x + 7x + x = ?$  / 1 оноо /

- A.  $-20x$                                       B.  $-6x$                                       C.  $-5x$                                       D.  $20x$

3.  $\frac{2}{5}$  ба  $\frac{3}{4}$ -ын хооронд орших тоо аль нь вэ? / 1 оноо /


- A. 0,2                                      B. 0,3                                      C. 0,4                                      D. 0,5

4.  $2x + 7 = 1$  шугаман тэгшитгэлийг бод. / 1 оноо /

- A. -3                                      B. 4                                      C. -4                                      D. 3

5. Дараах зургаас  $x$ -ийн утгыг олоорой. / 1 оноо /

- A.  $105^\circ$                                       B.  $115^\circ$                                       C.  $110^\circ$                                       D.  $145^\circ$



6. Улаанбаатраас Бээжин орох 5-н төрлийн тээврийн хэрэгсэл, Бээжингээс Москва орох 7төрлийн тээврийн хэрэгсэл байдаг бол, Улаанбаатраас Москва орох хичнээн ялгаатай төлөвлөгөө зохиож болох вэ? / 1 оноо /

- A.35                                      B.42                                      C.81                                      D.70

7. 5 шүдний эмч тутмын 3 нь чихэргүй шүдний оо хэрэглэхийг зөвлөдөг бол нийт эмч нарын хэдэн хувь нь чихэргүй оо хэрэглэхийг зөвлөдөг вэ? / 1 оноо /


- A. 20%                                      B. 30%                                      C. 40%                                      D.60%

8. 400, 200, 100, ... дарааллын 7-р гишүүн нь хэд вэ? / 1 оноо /

- A. 25                                      B. 10                                      C. 12,5                                      D.6,25

9.Зурагт өгсөн шулууны тэгшитгэлийг ол. / 1 оноо /


- A.  $y = 2$                                       B.  $y = 2x$                                       C.  $y = -x$                                       D.  $y = x$



10.Илэрхийллийг хялбарчил.  $3(2m + 1) - 2(m - 4) = ?$  / 1 оноо /

- A.  $4m - 5$                                       B.  $4m + 11$                                       C.  $8m - 5$                                       D.  $8m + 5$

11. Дараах дүрсүүдийг ажиглаад параллелиар зөөсөн хувиргалтыг сонгоорой. / 1 оноо /



12. 0-9 хүртлэх 10 цифрээс нэгийг сонгоход сондгой цифр гарч ирэх магадлалыг ол. / 1 оноо /

- A. 0.1                      B. 0.2                      C. 0.5                      D. 0.8

13.  $-4 \cdot \sqrt{36} + 7^2 = ?$  / 1 оноо /

- A. 95                      B. 130                      C. -10                      D. 25

14. Ногоочид өнгөрсөн жил тариалсан  $\frac{3}{4}$  га газраа нэмэгдүүлэн  $\frac{7}{8}$  га газарт хүнсний ногоо тариалжээ. Нэмэгдсэн газрын хэмжээг ол. / 1 оноо /

- A.  $\frac{1}{8}$                       B.  $\frac{3}{8}$                       C.  $1\frac{5}{8}$                       D.  $\frac{21}{32}$

15. Хаалтнаас ерөнхий үржигдэхүүн гаргаарай.  $12x + 18y =$  / 1 оноо /


- A.  $2(6x + 9y)$                       B.  $3y(4x + 6)$                       C.  $6(2x + 3y)$                       D.  $2x(6 + 9y)$

16. Хэрэв  $a = 4, b = 1$  бол  $\frac{a-1}{b+2}$ -ийн утгыг ол. / 1 оноо /

- A.  $\frac{1}{4}$                       B. 1                      C. 2                      D.  $\frac{1}{2}$

17. Нэг жижиг параллелолипедийн ирмэгүүд 2 см, 5 см, 7 см бол дараах биетүүдийн эзэлхүүнийг олоорой. / 1 оноо /

- A. 70 см.куб                      B. 700 см.куб                      C. 140 см.куб                      D. 560 см.куб



18. 2; 1.25; 2.3; 5.25; 2; 2.5 өгөгдлийн медиан ба далайцыг ол. / 1 оноо /

- A. медиан 2.15, далайц 4                      B. медиан 2, далайц 5.25                      C. медиан 2, далайц 4  
D. медиан 2.15, далайц 5.25

**2-р хэсэг Задгай даалгавар**

2.1 Огтлолцсон хоёр шулуунаар үүсэх өнцгүүдийн хоёр өнцгийн ялгавар нь  $30^0$  бол: /2оноо/

- A. Өнцгүүдээ зураарай.                      B. Өнцгүүдийг олоорой.

2.2 Пиктограммыг ашиглан асуултанд хариулаарай. /2оноо/

- A. Туяад хэдэн алим байсан бэ?                      B. Марал, Билгүүн хоёр нийлээд хэдэн алимтай байсан бэ?

Марал		Түлхүүр: = 2 алим
Бат		
Билгүүн		
Туяа		

2.3 3-т хуваахад 2 үлдэгдэл өгдөг тоонуудаар дараалал зохиожээ. /2оноо/

- A. Дарааллын эхний 4 гишүүнийг бичээрэй.                      B. Энэ дарааллын 10 дугаар гишүүнийг олоорой.


2.4 Нэг нь нөгөөгөөсөө 12 км/ц илүү хурдтай хоёр машин хоорондоо 210 км зайтай хоёр хотоос нэгэн зэрэг угталцан гарч 3 цаг яваад зөржээ. /2оноо/

- A. Машин тус бүрийн хурдыг олоорой  
B. Зөрснөөсөө хойш хэдэн цагийн дараа хоорондох зай нь 140 км болох вэ?

2.5 Координатын хавтгай дээр  $A(-5; 1), B(-1; 4), C(0; 1)$  цэгүүдийг тэмдэглэж: /2оноо/

A. ABC гурвалжин байгуулаарай.

B. Ох тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй хувиргаарай.



2.6 Д, А, Р, А, А, Л, А, Л гэсэн үсгүүдийг нэг нэгээр нь бичсэн картууд байв. Таамгаар нэг карт сонгоход: /2оноо/

A. Гийгүүлэгч үсэг таарах

B. Л үсэг таарах магадлалыг тус тус ол.

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН VI АНГИЙН  
МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар Е

ХУГАЦАА: 60 МИНУТ

НИЙТ ОНОО: 30

**1-р хэсэг Сонгох тест ( Бодлого бүр 1 оноо)**

1. -15 ба 5-ийн хооронд хэдэн бүхэл тоо орших вэ? /1 оноо/

A.5

B.10

C.15

D.20

2. Илэрхийллийн утгыг олоорой. /1 оноо/

$$\sqrt{225} + \sqrt{625} - 9^2 - (-6) =$$

A.227

B.-35

C.-227

D.35

3. ХИЕХ ХБЕХ – ийг олоорой.  $(48,64) =$  /1 оноо/

A. ХИЕХ = 24 ХБЕХ = 384

B. ХИЕХ = 384 ХБЕХ = 24

C. ХИЕХ = 16 ХБЕХ = 192

D. ХИЕХ = 192 ХБЕХ = 16

4. Бутархайнуудыг жишээрэй.  $\frac{7}{11}$  ба  $\frac{9}{10}$  /1 оноо/

A.  $\frac{7}{11} > \frac{9}{10}$

B.  $\frac{7}{11} = \frac{9}{10}$

C.  $\frac{7}{11} < \frac{9}{10}$

5. Батад 12000 төгрөг байв. Түүнийхээ 25%-ийг зарцуулжээ. Хичнээн төгрөг Батад үлдсэн бэ? /1 оноо/

A. 3000

B. 5000

C.6000

D. 9000

6. Пропорцыг бод.  $x:13 = 15:39$  /1 оноо/

A. 5

B.33.8

C. 45

D. 50

7.Савны  $\frac{3}{5}$  хэсгийг 42л усаар дүүргэжээ. Сав хэдэн литрийн багтаамжтай вэ? /1 оноо/

A. 47л

B.28л

C. 42л

D. 70л

8.Алгебрийн илэрхийллийг хялбарчлаарай. /1 оноо/

$$7(-4x + 7) + 8(3x - 7) =$$

A.  $-52x - 105$

B.  $52x + 105$

C.  $-4x - 7$

D.  $4x + 7$

9. Тэгшитгэл бод.  $4(x - 5) - 3(x - 7) = 2x - 10$  /1 оноо/

A. 57

B. 11

C. 15

D. 0

10. 6, 10, 14, 18, ... дарааллын зүй тогтол ба 20-р гишүүнийг олоорой. /1 оноо/

A. 2-оор нэмэгдэж байна, 20 дугаар гишүүн 65

B. 4-өөр нэмэгдэж байна, 20 дугаар гишүүн 82

C. 4 дахин нэмэгдэж байна, 20 дугаар гишүүн 82

D. 2 дахин нэмэгдэж байна, 20 дугаар гишүүн 56

11. Мэдэгдэхгүй байгаа  $x$  өнцгийн хэмжээг олоорой. /1 оноо/

A.  $180^\circ$

B.  $120^\circ$

C.  $100^\circ$

D.  $240^\circ$

12 .Зургаас  $x$  өнцгийн хэмжээг ол. /1 оноо/

A.  $45^\circ$

B.  $105^\circ$

C.  $60^\circ$

D.  $75^\circ$

13. 200дм =\_м шилжүүлээрэй. /1 оноо/


A.2000м

B.200м

C.20м

D.2м

14.  $1\text{м}^2 =$  \_\_\_\_\_ $\text{см}^2$  шилжүүлээрэй. /1 оноо/



A.100

B.1000

C.10000

D.1000

15. Тэгш өнцөгт гурвалжны талбайг ол. /1 оноо/

A.  $24\text{cm}^2$ B.  $48\text{cm}^2$ C.  $12\text{cm}^2$ D.  $14\text{cm}^2$ 

16. Дэлгүүрт 8 төрлийн аяга, 5 төрлийн дийз, 7 төрлийн халбага зарж байв. Аяга, дийз, халбага гэсэн иж бүрдлийг хэдэн янзаар худалдан авах боломжтой вэ? /1 оноо/

A. 20

B. 280

C. 91

D.3

17. 5см, 6см, 8см ирмэгүүдтэй тэгш өнцөгт параллелопидийн гадаргуугийн талбайг ол. /1 оноо/

A.  $28\text{cm}^2$ B.  $240\text{cm}^2$ C.  $118\text{cm}^2$ D.  $236\text{cm}^2$ 

18. 4см, 7см, 10см ирмэгүүдтэй тэгш өнцөгт параллелопидийн эзэлхүүнийг ол. /1 оноо/


A.  $28\text{cm}^3$ B.  $280\text{cm}^3$ C.  $21\text{cm}^3$ D.  $70\text{cm}^3$ **2-р хэсэг Задгай даалгавар**

2.1 Илэрхийллийг хялбарчлаарай. /2 оноо/

$$\left(\frac{4}{9} + \frac{5}{12}\right) \div 5\frac{1}{6} + \left(12 - 11\frac{2}{9}\right) \cdot \frac{7}{10} =$$

2.2 A(2;3), B(-3,3), C(-3, -2), D(2; -2) цэгүүдэд

оройтой ABCD квадрат өгөгдөв. (-4;4) чиглэлийн дагуу параллель зөөлт хийгээрэй. /2 оноо/



2.3 3-т хуваахад 2 үлдэгдэл өгдөг тоонуудаар дараалал зохиожээ. /2 оноо/

A. Дарааллын эхний 4 гишүүнийг бичээрэй.

B. Энэ дарааллын 10 дугаар гишүүнийг

олоорой.

2.4 Д, А,Р, А, А, Л, А, Л гэсэн үсгүүдийг нэг нэгээр нь бичсэн картууд байв. Таамгаар нэг карт сонгоход: /2 оноо/

A. Гийгүүлэгч үсэг таарах

B. Л үсэг таарах магадлалыг тус тус ол.

2.5  $4x-3=13$  тэгшитгэлийг бодоорой /2 оноо/

2.6 5-д хуваахад 2 үлдэгдэл өгдөг тоонуудаар дараалал зохиожээ. /2 оноо/

A. Дарааллын эхний 4 гишүүнийг бичээрэй.

B. Энэ дарааллын 15 дугаар гишүүнийг олоорой.

### Хариу

Хувилбар А			Хувилбар Б			Хувилбар В		Хувилбар Г		Хувилбар Д		Оноо
1	С	1	А	1	С	1	Д	1	Д	1	1	
2	А	2	В	2	С	2	С	2	В	2	1	
3	С	3	Д	3	В	3	Д	3	С	3	1	
4	В	4	Д	4	В	4	А	4	С	4	1	
5	В	5	С	5	С	5	В	5	Д	5	1	
6	В	6	С	6	С	6	А	6	А	6	1	
7	С	7	Д	7	С	7	Д	7	Д	7	1	
8	С	8	Д	8	С	8	Д	8	С	8	1	
9	Д	9	Д	9	Д	9	Д	9	В	9	1	
10	В	10	А	10	А	10	В	10	В	10	1	
11	Д	11	А	11	В	11	Д	11	В	11	1	
12	С	12	С	12	С	12	С	12	Д	12	1	
13	С	13	А	13	С	13	Д	13	С	13	1	
14	А	14	С	14	В	14	А	14	С	14	1	
15	А	15	А	15	С	15	С	15	А	15	1	
16	Д	16	В	16	А	16	В	16	В	16	1	
17	В	17	В	17	В	17	В	17	Д	17	1	
18	А	18	А	18	А	18	А	18	В	18	1	